



**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 10 сарын 24 өдөр

Дугаар A/189

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2022 оны А/189 дүгээр тушаалаар батлагдсан “Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Хөдөлмөрийн дотоод журам”-ын 2 дугаар зүйлийн 2.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эмийн биологийн идэвхт бүтээгдэхүүний 1994-2021 он хүртэлх бүртгэлийн материалын цахим архив үүсгэх, Монгол улсад бүртгэлтэй эм тус бүрийн заавар болон зургийг оруулах “Ажлын хэсэг”-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга	Л.Зэндмаа	Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын дарга
Гишүүд	Л.Батзориг	Захиргаа, удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Э.Азжаргал	Импортын эмийн бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн
	Ц.Амаржаргал	Оношлуурын бүртгэл, сунгалт, өөрчлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн
	Ч.Баяр	Үндэсний үйлдвэрийн эм, уламжлалт эмийн бүртгэл, сунгалт, өөрчлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн
	Г.Бүжмаа	Эмийн бүртгэлийн өөрчлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн
	Н.Гандолгор	Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн
	Э.Гэрэлт-Эрдэнэ	Бүртгэлийн мэдээний сангийн асуудал хариуцсан мэргэжилтэн
	Д.Тэргэл	Эмийн бүртгэлийн сунгалтын асуудал хариуцсан мэргэжилтэн

1422 011:9

Д.Тэргэл

Эмийн бүртгэлийн сунгалтын асуудал хариуцсан
мэргэжилтэн

Нарийн бичиг М.Долгион

Эмийн бүртгэлийн зохицуулалтын асуудал
хариуцсан ахлах мэргэжилтэн

2. Газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд орсон цахим архив үүсгэх ажлыг шуурхай хийж гүйцэтгэхтэй холбоотойгоор захиргааны санаачилгаар албан хаагчдыг ажлын бус цагаар ажиллуулах тохиолдолд хяналт тавиж ажиллахыг Агентлаг, хяналтын лабораторийн хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн (Н.Уянга)-д үүрэг болгосугай.

3. Илүү цагаар ажилласан хөлсийг Хөдөлмөрийн тухай хууль болон зохих журмын дагуу тооцож олгохыг Санхүү, төсвийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн (А.Болор-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Батзориг)-т даалгасугай.

ДАРГА



Д.НАРАНТУЯА